



**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2010 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

Ажил, үйлчилгээний чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн **ТУШААХ** нь:

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны төвлөрсөн арга хэмжээ, Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2010 онд төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү чиглэлд нийцүүлэн Төрийн зарим чиг үүргийг Төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Г.Энхтуяа/ -д даалгасугай.

3. Төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга /Х.Цолмон/-д даалгасугай.

ДАРГА



У.БЯМБАСҮРЭН

Төрийн нарийн бичгийн даргын
2010 оны 11 сарын 12 өдрийн
09 тоот тушаалын хавсралт



**Төрийн бус байгууллагаар 2010 онд гүйцэтгүүлэх
ажил, үйлчилгээний чиглэл**

1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл, сурталчилгаа хүргэх үйлчилгээ
2. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар зорилтот бүлэгт чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа явуулах үйлчилгээ
3. Хэрэглэгчээс үнэлгээ авах санал асуулгын арга зүйг боловсруулах
4. Хэрэглэгчээс үнэлгээ авах санал асуулгын тандалт судалгааг явуулах, дүгнэлт, зөвлөмж гаргах
5. Мал аж ахуйн үйлдвэрлэл дэх хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн өнөөгийн нөхцөл байдлын нарийвчилсан судалгаа, бодлогын зөвлөмж боловсруулах
6. Эмэгтэй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалтад үнэлгээ хийх, цаашид боловсронгуй болгох санал боловсруулах
7. Хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн харилцааны шинэчлэлийн хүрээнд хийгдэх судалгааны ажил
8. Сонсголын бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд нийцсэн сургалтын гарын авлага, материал боловсруулж, суралцах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх үйлчилгээ
9. Хүн худалдаалах гэмт хэргийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах, нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог хэрэгцээнд нийцсэн нийгмийн үйлчилгээ
11. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн зохион байгуулалтыг сайжруулах үйлчилгээ
12. Мэргэжлийн сургалт болон ажилд зуучлах үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үр өгөөжийн судалгаа, дүгнэлт
13. Бодлогын зөвлөгөө авах үйлчилгээ
14. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хэрэгжиж байгаа Үндэсний хөтөлбөрүүдэд судалгаа хийж, бодлогын зөвлөмж боловсруулах үйлчилгээ
15. Гадаадад ажиллаж, амьдарч байгаад ирсэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг судалж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах
16. Хөдөлмөрийн асуудлаархи хөтөлбөрүүдийн хэрэгжилт, цаашид боловсронгуй болгох талаар санал зөвлөмж боловсруулах